

**Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын
“Орхон хөгжил” ХК-ийн
2015 оны газар тариалангийн
үйлдвэрлэл болон үйл ажиллагааны тайлан**

Тариалалтын талаар:

Тайлант 2015 онд тариалангийн ажилд ашиглах техник тоног төхөөрөмжийн засварыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн,

Тариалалтыг 5-р сарын 04-ны өдрөөс 5-р сарын 29-ныг дуустал хугацаанд нийт 823 га-д хийж гүйцэтгэв. Тарихын өмнөх боловсруулалтыг трактор, сийрүүлэгчээр гүйцэтгэсэн бөгөөд 170 тн үрийг 8-10 см-ийн гүнд тариалав.

Тарианы соёлолт, ургалтын явцад бороо чийг сайн байсан тул ургац хураалт сайн байсан болно. Мөн тариан 43 га талбайд мал орсноос 20 га талбайн тариаг хурааж чадаагүй болно..

Ургац хураалтын талаар:

Комбайны засварын ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн 3 комбайныг бэлэн болгож ажиллуулсан. Хураалтын явцад комбайны эвдрэл бага зэрэг гарсан боловч цаг тухайд засварласан.

Тайлант онд 830 га талбайд уринш хийсэн. Уриншийн талбайд гербицид хороор боловсруулалт хийсэн. Хор цацах ажлыг 6-р сарын 15-аас 6-р сарын 25 хүртэл 10 хоног гүйцэтгэв. Уриншийн 2-р үеийн боловсруулалтыг 8-р сарын 8-аас эхэлж сийрүүлэлтийг 10 хоногт хийж гүйцэтгэлээ.

Ургац хураалт өөрийн машин техникийг ашиглан 40-45 хоног үргэлжлэв.

Үтрэмийн ажлын талаар:

Хураасан будаагаа өөрийн ачигч, цэвэрлэгч, сортлогч машиныг ашиглан стандартад нийцүүлэн ачуулсан болно.

2015 онд 1 га-гаас 9.05 цн буюу нийт 745 тн ургац хураасан бөгөөд үүнээс 529,94 тн будаа борлуулж, 304359,49 сая төгрөгний орлого олсон. 383308,2 сая төгрөгийн зардал гарсан бөгөөд 78948,7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЖАРГАЛСАЙХАН